



ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Аудитын сэдэв: “Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилт”

Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх: Аудитыг Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2022 оны “Аудитын сэдэв батлах тухай” 9 дүгээр тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын “Аудитын жилийн төлөвлөгөө батлах тухай” 2023 оны А/04 дүгээр тушаал, Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газрын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу “Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд гүйцэтгэв.

**БАЙГАЛИЙН НӨӨЦ АШИГЛАСНЫ ТӨЛБӨРИЙН
ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ 84.6 ХУВЬТАЙ
ХЭРЭГЖСЭН БАЙНА.**

Аудитын тайланг хүргүүлсэн: Дархан-Уул аймгийн ИТХ, Засаг дарга, Байгаль орчин аялал жуулчлалын газар, Сум дундын ойн анги, Хараа-Ерөө голын сав газрын захиргаа, Хонгор, Шарын гол сумын Засаг дарга

Нэмэлт мэдээлэл, мэдээллийн эх сурвалж:



ДАРХАН-УУЛ АЙМАГ

2023 оны 06 дугаар сар

Аудитын зорилго, зорилтууд:

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилтэд аудит хийж, дүгнэлт гарган, зөвлөмж боловсруулж, холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдэнэ.

Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэсэн. Үүнд:

- Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийг хэрэгжүүлэх эрх зүйн орчин, төрөөс баримтлах бодлогын баримт бичгийн хэрэгжилт хангагдсан эсэх;
- Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн төлбөрийн орлогын хэсгийн бүрдүүлэлт, зарцуулалт, хууль журмын дагуу хэрэгжсэн эсэх;
- Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийн нөхцөл байдалд тохирох арга хэмжээ авсан эсэх;

Аудитын хамарсан хүрээ:

Аудитад хуулийн хэрэгжилтийг хангах, төлөвлөх, хэрэгжүүлэх, хяналт тавих чиг үүрэг бүхий дараах байгууллагууд хамрагдсан.

Аудитад аймаг, сумын ИТХ, Засаг дарга түүний тамгын газар, аймгийн СТСХ, БОАЖГ, ГХБХБГ, Татварын хэлтэс, Сум дундын ойн анги, Хараа Ерөө голын сав газрын захиргааны 2021-2023 оны үйл ажиллагааг хамруулан гүйцэтгэсэн

БҮЛЭГ А. БАЙГАЛИЙН НӨӨЦ АШИГЛАСНЫ ТӨЛБӨРИЙН ТУХАЙ ХУУЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТ 84.6 ХУВЬТАЙ БАЙНА.

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль нь зарим хууль тогтоомж, журамтай уялдаагүй байна.

Аудитаар Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль нь Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, Газрын тухай хууль, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2022 оны 08 дугаар сарын 22-ны өдрийн А/282 дугаар тушаалын хавсралт "Ойн дагалт баялгийг хамгаалах, зохистой ашиглах" журамтай уялдаагүй, хууль нь батлагдаагүй, хугацаа нь зөрүүтэй тусгагдсан байна.

Аймгийн үндсэн чиглэл, Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан арга хэмжээ бүрэн хэрэгжсэн байна.

Аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийг боловсруулахдаа Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 1¹, 6 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн 4², 6 дугаар зүйлийн 7³, 6 дугаар зүйлийн 8⁴, 6 дугаар зүйлийн 9⁵, Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5-д "Алсын хараа 2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг, Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн баримт бичигтэй тус тус уялдуулан хяналт шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшинг тооцон боловсруулсан байна.

¹ Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг нь дэвшүүлсэн зорилго, зорилтоо хангахад чиглэгдсэн, харилцан уялдаа бүхий дараах төрөлтэй байна.

² байгаль орчны зорилтот хөтөлбөр,

³ Дунд хугацааны буюу таван жилийн хугацаанд хэрэгжүүлэх хөгжлийн төлөвлөлтийн баримт бичиг нь Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Аймаг, нийслэл, хотыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл байна.

⁴ Дунд хугацааны буюу дөрвөн жилийн хугацаанд хэрэгжүүлэх хөгжлийн төлөвлөлтийн баримт бичиг нь Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр байна.

⁵ Богино хугацааны буюу нэг жилийн хугацаанд хэрэгжүүлэх хөгжлийн төлөвлөлтийн баримт бичигт Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө, улсын төсөв, Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөө, Орон нутгийн төсөв хамаарна.

Дархан-Уул аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд “Ногоон хөгжил”-ийн бодлогыг 3 зорилт, 7 арга хэмжээ, Дархан-Уул аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт 4 зорилт, 12 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тус тус баталсан байна

Түүнчлэн дээрх арга хэмжээний хэрэгжилтийг аймгийн ЗДТГ-ын ХШҮДАХ-ийн 30-70 хувиар үнэлсэн үнэлгээг бодитой эсэхийг тулган шалгахад зөрүү илрээгүй.

Менежментийн төлөвлөгөөг хууль тогтоомж, бодлогын баримт бичигт нийцүүлэн өөрчлөлт оруулаагүй, мөн орон нутгийн хамгаалалттай газар нутгийн орчны бүсийн менежментийн төлөвлөгөөг боловсруулаагүй байна.

Аймгийн БОАЖГ нь 2022 онд ойн менежментийн төлөвлөгөөгүй ажилласан ба Ойн тухай хуульд 2017-2022 онд 7, Усны тухай хуульд 2019-2022 онд 5 удаа нэмэлт өөрчлөлт орсон ч ойн болон усны менежментийн төлөвлөгөөнд өөрчлөлт, шинэчлэлтийг хийгээгүй байна.

Аймгийн БОАЖГ нь Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.5⁶-д заасны дагуу Орон нутгийн хамгаалалттай газар нутгийн орчны бүсийн менежментийн төлөвлөгөөг боловсруулаагүй байна.

БОАЖС-тай байгуулсан гэрээний биелэлт 88.8 хувь хэрэгжсэн байна

Байгалийн нөөц ашигласны төлбөр, түүнтэй холбогдох харилцааг 2021 онд 18 арга хэмжээнээс 12 арга хэмжээг 100%, 1 арга хэмжээг 95%, нийт 99.0 хувиар, 2022 онд 13 арга хэмжээнээс 5 арга хэмжээг 100%, 3 арга хэмжээг 90%, 3 арга хэмжээг 96.6%, 2 арга хэмжээг 85%, нийт 95.9 хувиар хэрэгжилтийг тайлагнасан хэдийч БОАЖС, аймгийн Засаг даргатай байгуулсан хамтран ажиллах гэрээг 2021 онд 80.4, 2022 онд 88.8 хувиар дүгнэсэн байна.

Аймгийн Засаг дарга, сумдын Засаг дарга нартай байгуулсан гэрээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт 95.6 хувьтай хэрэгжсэн байна

Сумдын гүйцэтгэлийн төлөвлөгөө болон хамтран ажиллах гэрээнд байгалийн нөөц ашигласны төлбөр, түүнтэй холбогдох харилцааг тусгасан эсэхийг тулган шалгахад 2021 онд 226 арга хэмжээнээс 16, 2022 онд 119 арга хэмжээнээс 12 арга хэмжээ төлөвлөж, гүйцэтгэлээр 2021 онд 96.7, 2022 онд 94.6 хувьтай хэрэгжсэн байна.

БҮЛЭГ Б. БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ, НӨХӨН СЭРГЭЭХ АРГА ХЭМЖЭЭНД ЗАРЦУУЛАХ ТӨЛБӨРИЙН ОРЛОГЫН БҮРДҮҮЛЭЛТ ХАНГАЛТГҮЙ БАЙНА

Монгол Улсын байгалийн нөөцийг тогтоож, ашиглах төрөл, дээд хэмжээг үндэслэлтэй төлөвлөсөн байна..

БОАЖЯ-ны тушаал, аймгийн ИТХ-ын тогтоолыг үндэслэн ой мод, ургамал, ан, амьтан, усны нөөцийг Байгаль орчин, ногоон хөгжлийн яам, “Ойн судалгаа хөгжлийн төв” УТҮГ-аас 2013 онд хийсэн ойн нөөцийн тооллогод үндэслэн БОАЖС 2020 оны 599, 2021 оны 217 дугаар тушаалаар ойгоос бэлдэх модны дээд хязгаарыг тус тус тогтоосон байна.

Дээрх тушаалуудыг үндэслэн мод бэлтгэх дээд хязгаарт багтаан Дархан-Уул аймгийн ИТХ 2020 оны 99, 2021 оны 82, Хонгор сумын ИТХ 2021 оны 06, 2022 оны 40 дугаар тогтоолоор тус тус баталсан нь үндэслэлтэй байна.

Төлбөрийн орлогыг журамд заасны дагуу бүрдүүлээгүй байна

⁶ “Орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутаг менежментийн төлөвлөгөөтэй байж болох бөгөөд төлөвлөгөөг тухайн аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал батална”

Ойн нөөц ашигласны төлбөрийн орлогыг 2021 онд 4 нөхөрлөл, 2022 онд 1 аж ахуйн нэгж байгууллагаас нийт 6.4 сая төгрөгийн орлогын дутуу төвлөрүүлсэн байна.

Байгалийн нөөц ашиглах зөвшөөрлийг хууль тогтоомжийн дагуу олгосон байна

Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2-т “Сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын болон Засаг даргын бүрэн эрхийн хүрээнд иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад байгалийн баялгийн нөөц ашиглах эрхийн бичгийг хууль тогтоомжийн дагуу олгох” гэж заасны дагуу Хонгор сумын ИТХ-ын 2021 оны 02 дугаар сарын 04-ний өдрийн 06 тоот тогтоолыг үндэслэн 2021 онд 14 аж ахуйн нэгж, нөхөрлөлийн нийт 108.3 сая, 2022 онд 2 аж ахуйн нэгж байгууллагатай 14.7 сая төгрөгийн гэрээг тус тус байгуулж, Хонгор сумын 3 байгаль хамгаалагч 2021 онд 1,058, 2022 онд 735, нийт 1,793 эрхийн бичиг бичиж, ойн нөөцийн төлбөрийг нэр, регистрийн дугаараар татварын нэхэмжлэл үүсгэж, сумын төрийн сангийн дансанд төвлөрүүлсэн байна.

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлого жил бүр давж биелдэг ч 2023 онд төлөвлөгөөг бууруулан баталсан байна.

Аймгийн ИТХ-ын 2020 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 2/02 тогтоолоор байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогыг 2021 онд 429.3 сая, 2022 онд 577.8 сая, 2023 онд 431.6 сая төгрөгөөр тус тус баталж, орлогын гүйцэтгэл жил бүр 25.7 хувиар давж биелсэн ч төлөвлөгөөг бууруулан баталсан байна.

В.1. БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨСӨВ, ЗАРДЛЫН МЭДЭЭЛЛИЙГ БАЙРШУУЛДАГ ЦАХИМ СИСТЕМИЙН АШИГЛАЛТ ОРОН НУТАГТ ХАНГАЛТГҮЙ БАЙНА.

Байгаль орчныг хамгаалах арга хэмжээний төсөв, зардлын мэдээллийг цахим системд бүрэн байршуулаагүй байна.

Байгаль орчныг хамгаалах арга хэмжээний төсөв, зардлын мэдээллийн сангийн цахим системд аймгийн БОАЖГ-аас оруулсан мэдээг Санхүү төрийн сангийн байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх ангиллын зардлын гүйцэтгэлийн мэдээтэй харьцуулан үзэхэд төсөв, зарцуулалтын дүн таарахгүй байх, мэдээлэл оруулаагүй зэрэг нийтлэг алдаа гарч байна. Энэ нь Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 35 дугаар зүйл 35.1.17⁷, Засгийн газрын 2022 оны 2 дугаар тогтоол “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам”-ын 1.2⁸-т заасантай тус тус нийцэхгүй байна.

Аймгийн БОАЖГ-ын цахим систем хариуцсан мэргэжилтнээс тодруулахад уг цахим систем 2022 оны хагас жилээс хойш хэрэгжиж эхэлсэн, ашиглах заавар, танилцуулга, сургалт бүрэн хийгдээгүй, 2023 онд БОАЖГ-аас нэгдсэн сургалтыг хийхээр төлөвлөсөн байгаа гэсэн тайлбар ирүүлсэн.

Төрийн болон нутгийн захиргааны байгууллагын мэдээ тайлан зөрүүтэй илэрхийлэгдэж байна.

Аймгийн СТСХ-ийн мэдээ тайланг татварын хэлтсийн мэдээ тайлан, БОАЖГ-ын Байгаль орчныг хамгаалах арга хэмжээний төсөв, зардлын мэдээллийг байршуулдаг /eic.mn.finance/ цахим системийн мэдээнүүдтэй харьцуулан үзэхэд татварын мэдээнээс 16.6 сая, БОАЖ-ын газрын цахим системээс орлого 1,704.0 сая, зардлын гүйцэтгэлээс 445.0 сая төгрөгөөр зөрүүтэй байна.

⁷ байгаль орчныг хамгаалах арга хэмжээний төсөв, зардал;

⁸ Төлбөрийн орлогын хэсгийг төлөвлөх, тайлагнахад энэ журмын хавсралт маягуудыг (цаашид “БНАТ маягт” гэх) ашиглах бөгөөд Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 35.1.17-д заасан Байгаль орчныг хамгаалах арга хэмжээний төсөв, зардлын мэдээллийн санд цахимаар байршуулна.

Хяналтын тогтолцоог хэрэгжүүлэх хууль эрх зүйн орчин хангалтгүй байна.

Хонгор сумын ИТХ 2021 оны 06, 2022 оны 40 дугаар тогтоолуудаар 2021 онд ойн мэргэжлийн 5 байгууллагад арчилгааны огтлолд 1,550 м³, цэвэрлэгээний огтлолд 1,000 м³, ойн 9 нөхөрлөлд 1,000 м³ ойн цэвэрлэгээний мод, 2022 онд ойн мэргэжлийн 5 байгууллагад арчилгааны огтлолд 1,550 м³, цэвэрлэгээний огтлолд 1,300 м³ мод бэлтгэх хуваарь баталсан байна.

Харин аймгийн Сум дундын ойн анги ойн мэргэжлийн байгууллага, нөхөрлөлүүдтэй мод бэлтгэх гэрээ байгуулан ажиллаж ирсэн ч гэрээ дүгнэсэн акт үйлдэгдээгүй нь Ойн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2.6⁹, мод бэлтгэх гэрээний 4.7¹⁰, 3.9¹¹-тэй нийцэхгүй байна.

Аудитаар Хонгор сумын Зулзагын гол багт байршилтай иргэн, аж ахуй нэгж, байгууллагын 15 худгийг шалгахад техникийн паспорт, байгуулсан гэрээгүй, усны дүгнэлтгүй, тоолуур тавиагүй, усны дүгнэлт гаргуулан гэрээ байгуулсан ч үйл ажиллагаа явагдаагүй, гэрээг цуцалсан албан бичиг баримт байхгүй зэрэг зөрчлүүд байна. Энэ нь Усны тухай хуулийн 19.1.4¹², 28.4¹³, 28.5¹⁴, 28.6¹⁵, 28.11¹⁶ гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

ДҮГНЭЛТ:

Аудитаар нийт 157.9 сая төгрөгийн алдаа зөрчил илэрч, үүнээс дутуу төвлөрүүлсэн орлогын 6.4 сая төгрөгийн төлбөрийн акт, хангалтгүй хийгдсэн нөхөн сэргээлтийн ажлыг дахин хийлгэх 54.0 сая төгрөгийн 2 албан шаардлага хүргүүлэн, цаашид үйл ажиллагаанд мөрдөж ажиллах 97.5 сая төгрөгийн 11 зөвлөмж өгсөн.

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг өгсөн.

- Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн хэрэгжүүлэх эрх зүйн орчин, төрөөс баримтлах бодлогын баримт бичгийн хэрэгжилт 84.6 хувьтай байна.
- Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийн бүрдүүлэлт, зарцуулалт хангалтгүй байна.
- Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн хэрэгжилтэд тавих дотоод хяналтыг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүн, дүгнэлт нотлох зүйлст үндэслэн дараах зөвлөмжийг өгсөн. Үүнд:

⁹ энэ хуулийн 18.1.4-т заасан шийдвэрийг үндэслэн ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагад ойн сангийн тодорхой хэсгийг болзол, хугацаатайгаар эзэмшүүлэх гэрээ байгуулах, биелэлтэд хяналт тавих;

¹⁰ Мод бэлтгэх гэрээнд заасан хугацаанд мод бэлтгэлийн ажил дуусгавар болсны дараа 7 хоногийн дотор талууд гэрээг дүгнэж “Гэрээ дүгнэсэн акт” үйлдэнэ.

¹¹ Мод бэлтгэх гэрээнд заасан хугацаанд мод бэлтгэлийн ажил дуусгавар болсны дараа 7 хоногийн дотор талууд гэрээг дүгнэж “Гэрээ дүгнэсэн акт” үйлдэнэ.

¹² энэ хуулийн 28.6-д заасан зөвшөөрлийг үндэслэн ус ашиглагчтай гэрээ байгуулан эрхийн бичиг олгож бүртгэх, мэдээллийг сав газрын захиргаа, аймаг, нийслэлийн байгаль орчны албанд хүргүүлэх

¹³ Хоногт 100 шоомтрээс их ус ашиглах, эрчим хүч, усан тээврийн зориулалтаар ашиглуулах дүгнэлтийг усны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, 50-100 шоомтр ус болон усан орчин ашиглуулах дүгнэлтийг сав газрын захиргаа, 50 шоомтр хүртэлх ус ашиглуулах, хурын ус хуримтлуулж, хөв, цөөрөм байгуулах, суваг, шуудуу татах дүгнэлтийг аймаг, нийслэлийн байгаль орчны алба тус тус гаргана.

¹⁴ Энэ хуулийн 28.4-т заасан этгээд ус ашиглах тухай хүсэлтийг хүлээн авснаас хойш ажлын 15 өдрийн дотор дүгнэлт гаргана.

¹⁵ Энэ хуулийн 28.4-т заасан дүгнэлтийг үндэслэн ус ашиглах зөвшөөрлийг хоногт 100 шоомтрээс их ус ашиглах тохиолдолд сав газрын захиргаа, хоногт 50-100 шоомтр ус ашиглахад аймаг, нийслэлийн байгаль орчны алба, хоногт 50 шоомтрээс бага ус ашиглахад сум, дүүргийн Засаг дарга олгож, усны мэдээллийн санд бүртгэнэ.

¹⁶ Энэ хуулийн 28.6-д заасан зөвшөөрлийг үндэслэн ус ашиглах эрхийн бичиг олгож, гэрээ байгуулснаар иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын ус ашиглах эрх үүснэ.

Аймгийн ИТХ-ын дарга С.Насанбатад зөвлөсөн:

1. Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх ангиллын зардлаас зориулалтын бус арга хэмжээг батлахгүй байх
2. Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсэгт заасны дагуу хөтөлбөрүүдийн хэрэгжилт, биелэлтэд хяналт тавих

Аймгийн БОАЖГ-ын дарга Г.Батбаярт зөвлөсөн:

1. Менежментийн төлөвлөгөөг хууль тогтоомж, бодлогын баримт бичигт нийцүүлэн шинэчлэн батлах
2. Орон нутгийн хамгаалалттай газар нутгийн орчны бүсийн менежментийн төлөвлөгөөг боловсруулах
3. Байгаль орчин, аялал жуулчлалын газар, аймгийн ЗДТГ-ын санхүү төрийн сангийн хэлтэс, Татварын хэлтсийн мэдээ тайлангийн дүнг тулган баталгаажуулж байх
4. Худаг, ус ашиглалтын дүгнэлтийг гаргаж, гэрээ байгуулан, дүгнэж байх
5. БОАЖГ-аас eis.mn/finance/ системд Байгаль орчныг хамгаалах арга хэмжээний төсөв, зардлын мэдээллийг бүрэн байршуулах
6. БОХНС арга хэмжээний зардлаас зориулалтын бус хөтөлбөрт зарцуулахгүй байх

Аймгийн Сум дундын ойн ангийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Н.Болор-Эрдэнэд зөвлөсөн:

1. Ойн мэргэжлийн байгууллага, нөхөрлөлүүдтэй мод бэлтгэх гэрээг дүгнэж байх

Аймгийн Хараа-Ерөө голын сав газрын захиргааны дарга Ө.Ариунбаатарт зөвлөсөн:

1. Менежментийн төлөвлөгөөг хууль тогтоомж, бодлогын баримт бичигт нийцүүлэн шинэчлэн баталж, ажиллах

Хонгор сумын Засаг дарга Т.Атархишигт зөвлөсөн:

Мод бэлтгэх эрхийн бичгийн олголтыг үндэслэн тайлан, мэдээг үнэн зөв тайлагнах